



БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ХУРЛЫН ТОГТООЛ

2018 оны 02 сарын 21 өдөр

Дугаар 09

Номгон

Тогтоол хүчингүй болгох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн 62 дугаар зүйлийн 62.2, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 25.4, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Бууцагаан сумын эрүүл мэндийн төвийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй хуучин эмнэлгийн барилгыг аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн эх үүсвэрээр 20,0 сая төгрөгөөр засварлан ахуйн үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа, мөн сургуулийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй дотуур байрны барилгыг 2018 онд аймгийн болон сумын орон нутгийн хөгжлийн сангийн 140,0 сая төгрөгийн эх үүсвэрээр засварлахаар зураг төсөв хийгдэж, аймгийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан тул аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2016 оны 10 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтын 3,8 дугаар мөрүүдэд заагдсан барилгыг худалдах заалтыг хүчингүй болгосугай.

2. 2017 онд хувьчлах хөрөнгийн жагсаалтыг батлахдаа аймгийн Орон нутгийн өмчийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй Галуут сумын нутагт байрлах Ахмадын амралтын барилгыг хувьчлах талаар аймгийн хурлын хуралдаанаар хэлэлцүүлээгүй хууль зөрчин шийдвэр гаргасан тул аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 109 дүгээр тогтоолыг хүчингүй болгосугай.

3. Баянхонгор сумын Наранмандмал өрхийн эрүүл мэндийн төвийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй суудлын автомашиныг 70 дугаар байрны машины зогсоолд лацдаж үлдээсэн боловч салхины урд шил, хаалганы 5 шил, 2 ширхэг толийг хагалж ашиглах боломжгүй болгосон бөгөөд аймгийн Цагдаагийн газарт мэдэгдэж хэрэг үүсгэсэн боловч одоо хүртэл эзэн холбогдогч тогтоогдоогүй байгаа тул 20-88БНХ улсын дугаартай toyoto vitz маркийн автомашиныг акталж данснаас хасаж аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 60 дугаар тогтоолын 1 дүгээр заалтын

Баянхонгор сумын Наранмандмал өрхийн эрүүл мэндийн төв гэснийг, хавсралтын 1 дүгээр мөрүүдэд заагдсан автомашин худалдах гэсэн заалтыг хүчингүй болгосугай.

4. Аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга /Ч.Мөнхцэцэг/-д дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай.

4.1 Дээрх тогтоолууд хүчингүй болсонтой холбогдуулан барилгыг эзэмшигч байгууллагын дансанд хэвээр үлдээх, актлагдсан автомашинаас сэлбэгээр ашиглаж болох эд ангийг худалдан борлуулсан орлогоос “Өнөөгийн Баянхонгор” сонинд зарлуулсан зарын үнийг төлж үлдэгдэлийг Төрийн сан банкин дахь Орон нутгийн өмчийн газрын 100030051006 тоот дансанд төвлөрүүлэх;

4.2 Хөрөнгийн хөдлөл өөрчлөлтийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

4.3. Энэ тогтоолын хэрэгжилтийг 2018 оны 2 дугаар улиралд багтаан аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын ажлын албанд ирүүлэх.

5. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга /С.Үнэнбуян/-д даалгасугай.

ДАРГА



Ц.ОТГОНБАЯР